

**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

№	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур Үзүүлэлт	Суурь Түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ: “ОСОЛ, ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГО БҮХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭХ”							
НЭГ. ОСОЛ, ЗӨРЧЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ АВАХ, АНГИЛАН БҮРТГЭХ							
1	1.1	Аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлнэ.	Мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	ИНД-12 “Осол, зөрчлийг мэдээлэх” дүрмийн дагуу 2021 онд мэдээллийг бүрэн авч, нийт 24 тохиолдол ангилан, бүртгэж, сан үүсгэсэн. 2014-2021 оны бүртгэлд дүн шинжилгээ хийгдсэн.	Мэдээллийг бүрэн авч, ангилан бүртгэж, санг нэмэгдүүлсэн байна. Жилийн эцэст: Мэдээллийг бүрэн авч, ангилан бүртгэж, санг нэмэгдүүлсэн байна.	ИНЕГ-аас нислэгийн саатал, зөрчил, дутагдлын 352 тохиолдлын мэдээ, МИАТ ХК-иас 7 мэдээ, Аэромонголиа ХХК-иас 4 мэдээ, Монголиан Эйрвэйз ХХК-иас 2 мэдээ ирсэн. 2022 онд нийт 33 зөрчлийн тохиолдлоос осол-1, ноцтой зөрчил-0, зөрчил-32 бүртгэгдсэн байна. Үүнээс: 1.Нислэгийн ашиглалтын заавар зөрчигдсэн /Холбоо бариагүй/ – 1 2.Агаарын хөлгийн техникийн дутагдал /хөдөлгүүр, эд анги г.м / – 19 3.Агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн тохиолдол – 10 4. 2-р тойрог нислэгт гарсан тохиолдол – 3 байна. Нислэгийн тоо нэмэгдсэнтэй холбоотой зөрчлийн тоо өнгөрсөн оны /25 зөрчил/ байдлаас 1,32 дахин өссөн үзүүлэлттэй байна.	100

2	1.2	Нислэгийн зөрчлийг бүртгэх мэдээлэх, цахим хуудасны үйл ажиллагааг шинэчлэн сайжруулна.	Цахим үйл ажиллагааг сайжруулж шинэчилсэн эсэх	Бүртгэлийн ECCAIRS програмыг ашиглаж, цахим хуудсаар мэдээлэл авч байгаа.	Хагас жилийн байдлаар: Мэдээллийг цахимжуулах цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулсан байна. Жилийн эцсийн байдлаар: Мэдээллийг цахимжуулах цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж шинэчилсэн байна.	Цахим хуудсыг дотоод нөөц бололцоог ашиглан шинээр хийлгэх ажиллагаа явагдаж байна. Цахим хуудсанд орох мэдээлэл, ашиглах зарчим, шаардлагатай үзүүлэлт зэргийг бэлтгэн өгч байна. Мэдээлэл өгөх, авах ажиллагааг бүрэн цахимжуулах, ECCAIRS програмтай холбох, албан болон сайн дурын мэдээ хүлээн авах ажиллагааг хурдан шуурхай, нууцлалын баталгаатай болгож сайжрууллаа. Аюулгүй ажиллагааг сайжруулах зорилго бүхий осол, зөрчлийн мэдээллийн санг үүсгэх програмыг Update хийн сайжруулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийн ажиллаж байна.	70
ХОЁР. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ТОГТООХ							
3	2.1	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарсан тохиолдолд шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргана.	Шинжлэн шалгах ажиллагаа хийгдэж тайлан гаргасан эсэх	13-р Хавсралтын 6-р зүйл, ИНД-203, албаны дүрмийн 2.1, 3.3.22-н дагуу 2021 онд 6 шинжлэн шалгах ажиллагаа хийгдэж, 5 эцсийн тайлан, 1 урьдчилсан тайлан гарсан.	Хагас жилийн байдлаар: Осол, ноцтой зөрчлийн үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргасан байна. Жилийн эцсийн байдлаар: Осол, ноцтой зөрчлийн үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан	Тайлангийн хугацаанд шинжлэн шалгах ажиллагааны 2 урьдчилсан тайлан, 1 эцсийн тайлан гаргаж, дүгнэлт, зөвлөмжийн хамт холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Ослыг шинжлэн шалгах 1 ажиллагаа үргэлжилж байна. Үүнд: -EMB-145LR, JU-1800 бүртгэлийн дугаартай агаарын хөлөг 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Доной чиглэлийн нислэг үйлдэхээр "Чингис хаан" олон улсын нисэх буудлаас хөөрөх үед 2-р дугуй задарч хагарсан зөрчлийг тус албанаас шинжлэн шалгасан урьдчилсан тайланг 2022.02.08-ны 10/22 тоот албан бичгээр ИНЕГ-т, 11/22 тоот албан бичгээр АэроМонголиа ХХК-д, 12/22 тоот албан бичгээр "Чингис Хаан" ОУНБ-д,	100

				<p>гаргасан байна. ЗТХЯ-нд танилцуулахаар 2022.02.08-ны 13/22 Зөрчлийн үндсэн тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. шалтгаан нөхцөл, Уг шинжлэн шалгах ажиллагааны тайланд санал түүнд нөлөөлсөн хүсэлт, тайлбар, мэдээллийг дээрх хүчин зүйлийг байгууллагуудаас хүлээн авч хуулийн хугацаанд тодорхойлсон шийдвэрлэн эцсийн тайланг гарган 2022.03.01-тайлангийн төслийг ний 16/22 тоот албан бичгээр ИНЕГ-т, 2022.03.01-холбогдох ний 17/22 тоот албан бичгээр Аэро-Монголиа газруудад ХХК-д, 2022.03.01-ний 18/22 тоот албан бичгээр хүргүүлж, санал Чингис Хаан ОУНБ-д, 2022.03.01-ний 19/22 тоот авна. албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>-B767-300, JU-1021 агаарын хөлгийн 2022.09.12-ны өдрийн нислэгт цахилгаан тэжээл үүсгэгчүүд ажиллагаагүй болсон зөрчлийг шинжлэн шалгаж, техникийн үзлэг шалгалт, бичлэг тайлах ажиллагаа, хүний хүчин зүйл, бичиг баримтын шинжилгээний ажил хийгдэж, тайлан дүгнэлт гаргасан байна. Тайлангийн төслийг 2022.11.30-ны 86/22 тоот албан бичгээр ЗТХЯ-нд 85/22 тоотоор МИАТ ХК-д, 84/22 тоотоор ИНЕГ-т тус тус санал авахаар хүргүүлээд байна.</p> <p>-Монголиан Эйрвэйз ХХК-ний Н125 маягийн JU-6888 бүртгэлийн дугаартай нисдэг тэрэг 2022.09.25-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын нутагт хээрийн бууулт үйлдэж осолдсон шалтгааныг тогтоох шинжлэн шалгах ажиллагаа явагдаж байна. НТОЗШША-ны даргын 2022.09.26-ны А/08 тоот "Шинжлэн шалгах багийг томилох тухай" тушаалаар томилогдсон баг шинжлэн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэж байна. Нисдэг тэрэгний үйлдвэрлэгч, Францын ШШБ /BEA/-тай хамтран техник, эд анги, металын шинжилгээ хийн баримт бичгийн үзлэг шалгалт</p>
--	--	--	--	--

						хийгдэж, дүгнэлт гаргах ажиллагаа явагдаж байна.	
4	2.2	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед болон шаардлагатай тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаа явуулж, тайлан, дүгнэлт гаргана.	Шинжлэн шалгах ажиллагаа явуулж, тайлан гаргасан эсэх	13-р Хавсралт, ИНД-203, Албаны дүрмийн 2.2-ийн дагуу 2021 онд 4 шинжлэн шалгах ажиллагаа хийгдэж тайлан, дүгнэлт гаргасан.	Хагас жилийн байдлаар: Осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргана. Жилийн эцсийн байдлаар: Осол, ноцтой зөрчлөөс бусад зөрчил, тохиолдлын үед шинжлэн шалгах ажиллагааг явуулж, тайлан гаргана.	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 04 дүгээр шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ЕМВ-145 маягийн JU-1800 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн дугуй хагарсан зөрчлийг шалгах ажлын хүрээнд “Чингис хаан” ОУНБ-ын аэродром хариуцсан холбогдох албан тушаалтнуудтай уулзаж мэдээлэл авч, судалгаа хийсэн. Ханбумбат НБ-д аэродромын хөөрч, буух зурвас, перрон зогсоолд очиж хэмжилт шалгалт хийж, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, удирдах албан тушаалтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулав. ИНЕГ-ын НААХЗА-ны үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх тухай ЗТХС-ын 2022.11.02-ны өдрийн 01/5030 тоот албан бичгийн дагуу тус албанаас иргэний нисэхийн аюулгүй байдал, түүнд тавих, хяналт зохицуулалтад судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэн тайлан гаргасан байна. Тайланг 2022.11.16-ны 83/22 тоот албан бичгээр ЗТХ-ийн сайдад танилцуулахаар хүргүүлсэн. - Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан хяналт, шалгалтын удирдамжийн дагуу “Изинис Эйрвэйз” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажлын тайланг 2022.12.16-нд Зам, Тээврийн хөгжлийн сайдад тайлагнав.	100
5	2.3	“Чингис хаан” ОУНБ-ын	Судалгаа, шинжилгээ	-	Эхний хагас жилд:	ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын албанд “Чингис хаан” ОУНБ-ын	70

		аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж тайлагнана.	хийж тайлагнасан эсэх		Албаны дүрмийн 3.3.7-ийн дагуу "Чингис хаан" ОУНБ-ын аюулгүй ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гарган Зам, тээврийн хөгжлийн сайдад тайлагнана.	аюулгүй ажиллагаанд судалгаа шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг ирүүлэх албан бичиг хүргүүлэв. /2022.06.13-ны 45/22 тоот/ ИНЕГ-ын 2022.06.23-ны 03/1145 тоот бичгээр ирсэн хариуг үндэслэн судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах ажиллагаа явагдсан. Тайлан дүгнэлтийг 2022.12.19-ний 88/22 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулахаар хүргүүлсэн.	
ГУРАВ. ОСОЛ, ЗӨРЧИЛ ДАВТАГДАН ГАРАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ ГАРГАХ							
6	3.1	Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны тайланг үндэслэн нислэгийн аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргана.	Аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргасан байна.	13-р Хавсралт, ИНД-203-ын дагуу 2021 онд 14 аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргасан.	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: Нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах зорилгоор шинжлэн шалгасан тайланг үндэслэн осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг гаргана.	2022 онд шинээр 10 аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргасан байна. ИНЕГ, Аэромонголиа ХХК-т. ЗӨВЛӨМЖ 202202/01. Аэромонголиа ХХК-ийн нислэгийн үйл ажиллагаанаас үзэхэд нислэгт нөлөөлөх хязгаарлалт \limitations\-ууд тогтмол зөрчигдөж байгаа тул дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд: Нислэгт сөргөөр нөлөөлөх \Taxi exceedance in turn, Taxi speed exc. straight, Tire limit speed, High acceleration at touchdown, Overweight landing, High speed at landing, Late rotation, Questionable braking at landing\ болон бусад хязгаарлалт \limitations\-уудыг хянах, үр дүнг хэлэлцэж алдааг засах, нисгэх бүрэлдэхүүний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн тогтолцоог бүрдүүлэх. ЗӨВЛӨМЖ 202202/02. Аэромонголиа ХХК-ийн ЕМВ-145 агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрт резин дугуйны даралтын үзлэгийг 2	100

					<p>өдөр тутам Engineering order form техник үйлчилгээний хүрээнд гүйцэтгэж байгааг өөрчилж дугуй үйлдвэрлэгчийн болон SNL 145-32-0002 dated 30 April 2002 бюллетень-ийн дагуу 24 цаг тутамд дугуйны хийн даралтыг үздэг болгохоор хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202202/03. Агаарын хөлгийн дугуйны даралтын үзлэгээр хэт өөрчлөлт гарсан болон давтан гарсан шалтгааныг тогтоогоогүй, үзлэг үйлчилгээ хийсэн эсэх нь тодорхой бус, цаг агаарын өөрчлөлтийн нөлөөлөл даралтын хэмжилтийн үр дүн зөрөөтэй нь бодит байдал болон үйлдвэрлэгчийн заавар зөвлөмжид нийцэхгүй байсан тул дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд: Дугуйны хийн даралтын өдөр тутмын үзлэгийн үр дүнгийн бодит байдалд хяналт хийдэг тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202202/04. Дугуйны хийн даралт хэмжигч /tyre pressure gauge/-ийн тохирлын баталгаажуулалт болон ашиглалтыг сайжруулж загвар \эталон\ даралт хэмжигчтэй болох, түүгээр хэмжигчүүдийн найдвартай ажиллагааг байнга шалгаж байх.</p> <p>ИНЕГ, Чингис хаан ОУНБ-д.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202202/05. Аэродромын хөөрч, буух хатуу хучилттай зурвасны бүтцэд эвдрэл гарсан тохиолдолд шалтгааныг тогтоож, аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202202/06. Нисэх буудлын талбайд ажилладаг бүх байгууллага /агаарын хөлгийн ашиглагч, нислэгийн хоолны үйлчилгээ, цэвэрлэгээ болон бусад/-ын ажилтанд гадны</p>
--	--	--	--	--	---

					<p>биет /FOD/-ын эрсдэл түүнээс хамгаалах арга хэмжээний талаар нэгдсэн сургалтыг зохион байгуулах, сургалтын тогтолцоог бүрдүүлэх.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202211/07. ИНЕГ-т, МИАТ ХК-д. EC145, AS350(H125), EC130, ROBINSON R66 зэрэг нисдэг тэрэгт шинээр бэлтгэгдсэн нисгэх бүрэлдэхүүний онол, нислэгийн шалгалтыг дахин авч баталгаажуулах, онцгой болон хэвийн бус ажиллагаа /emergency and abnormal proceduers/ үүнд AUTOROTATION, LOSS OF TAIL ROTOR CONTROL-ийг хамааруулан дадлага хийлгэсний үндсэн дээр нислэгт гаргах.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202211/08. ИНЕГ-т, МИАТ ХК-д. JU-1021, B767-300 агаарын хөлгийн цахилгаан системийн найдвартай ажиллагааны тодорхойгүй байдлын судалгааг төрөл бүрийн эх үүсвэрээс үндэслэн хийж /analysis of multiple source data, e.g., laboratory failure data, similar components' history operating data, data given by component suppliers, etc/ холбогдох арга хэмжээг авах.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202211/09. ИНЕГ-т, МИАТ ХК-д. JU-1021, B767-300 агаарын хөлгийн цахилгаан системд үйлдвэрлэгч, засварын байгууллагын дэмжлэгтэй үзлэг үйлчилгээ хийж системийн найдвартай ажиллагааны баталгааг хангах.</p> <p>ЗӨВЛӨМЖ 202211/10. ИНЕГ-т, МИАТ ХК-д. Арилжааны нисгэгчийн үнэмлэх/CPL/-тэй нисгэгчийг агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх /ATPL/ эзэмших эрх олгоход онолын бүрэн сургалтанд хамруулсны үндсэн дээр шалгалт авах, сургалт болон шалгалтанд хамрагдаж тэнцсэн тохиолдолд дадлагажих нислэгт гаргаж байх.</p>	
--	--	--	--	--	---	--

7	3.2	<p>Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг бүртгэн хяналт тавьж, тайлагнана.</p>	<p>Тайлагнасан эсэх</p>	<p>Албаны дүрмийн 3.3.24, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020.10.21-ний өдрийн 04 тоот албан даалгаврын дагуу аюулгүй ажиллагааны зөвлөмжийн биелэлтийг гарган улирал бүр танилцуулсан.</p>	<p>Хагас жилийн эцсийн байдлаар: Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг зөвлөмж өгөгдсөн байгууллагаас биелэлтийг бүртгэн авч, дүгнэн Зам, тээврийн хөгжлийн сайдад сар бүр тайлагнана.</p>	<p>Тайлангийн хугацаанд шинээр гаргасан 10 зөвлөмж, өмнөх оны 8 зөвлөмж, нийт 18 зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн үзэхэд: 100% хэрэгжсэн -10 80% хэрэгжсэн-1 50% хэрэгжсэн -0 30% хэрэгжсэн- 2 20% хэрэгжсэн -1 Хэрэгжүүлэх хугацаа болоогүй-4 зөвлөмж байна. Биелэлт 82,85 %-тай байна. Хугацааны эхэнд зөвлөмжийн биелэлт 34,4 хувьтай байсан бол жилийн эцсийн байдлаар 82,85 хувь болж, 2,4 дахин өссөн байна. ИНЕГ, НААХЗА, МИАТ ХК, агаарын тээврийн компануудын удирдлагуудтай уулзалт ярилцлага хийн зөвлөмжийн биелэлтийн талаар харилцан зөвшилцөж, зөвлөмжийн биелэлтийг хугацаатай болгосон байна. Зөвлөмжийн биелэлтийг цаг тухайд нь дүгнэн сар бүр танилцуулдаг байсан бөгөөд одоогоор 14 хоног тутам танилцуулж байна. -Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг зөвлөмж өгөгдсөн байгууллагуудаас сар бүр авч “Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу үнэлэлт, дүгнэлт хийж байна. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийн тухай Зам, тээврийн хөгжлийн сайд болон зөвлөмж өгөгдсөн байгууллагуудад дараах албан бичгээр хүргүүлсэн байна. 2022.01.20-ны 03/22 тоот, 2022.02.01-ний 09/22, 2022.03.04-ний 23/22 тоот. 2022.04.15-ны 35/22 тоот, 2022.06.03-ны 42/22 тоот албан бичгээр</p>	70
---	-----	--	-------------------------	--	---	---	----

						Зам, тээврийн хөгжлийн сайдад, 41/22-оор ИНЕГ-т, 43/22 тоотойр ИНБХЗГ-т тус тус танилцуулсан. 2022.07.27-ны 53/22 тоот албан бичгээр ЗТХ-ийн сайдад, 54/22 тоот албан бичгээр ИНБХЗГ-т, 52/22 албан бичгээр ИНЕГ-т, 2022.08.26-ны 58/22 тоотойр ИНЕГ-т, 59/22-р ЗТХЯ-д, 60/22-р ИНБХЗГ-т тус тус хүргүүлэв. 2022.08.26-ны 58/22 тоотойр ИНЕГ-т, 59/22-р Зам, Тээврийн хөгжлийн сайдад, 60/22-р ИНБХЗГ-т тус тус хүргүүлэв.	
ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
ДӨРӨВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ							
8	4.1	2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган тайлагнаж дүгнүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланг хугацаанд гаргаж, хувьтай дүгнэгдсэн. нь 90,5	Хагас жилийн байдлаар: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр хугацаанд нь гарган дүгнүүлнэ. Жилийн эцсийн байдлаар: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсээр хугацаанд нь гарган дүгнүүлнэ.	2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган ЗТХЯ-ны ХШҮДАГ-т дүгнүүлэхээр 2022.12.09-ний дотор хүргүүлэв. Харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүртгэх, дүгнэх “Эйбл” програмд жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг гарган хугацаанд нь оруулаад байна.	100
9	4.2	Мэдээллийн илт тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	Байршуулсан мэдээллийн тоо	Тайлан, аюулгүй ажиллагааны зөвлөмж,	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: Мэдээллийг цахим	Албаны үндсэн чиг үүргийн дагуу шинжлэн шалгах ажиллагааг явуулж, агаарын хөлгийн осол, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож, гаргасан тайлан, дүгнэлт, аюулгүй ажиллагааны	70

		хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтоосон хугацаанд байршуулна.		дүрэм, журам, тушаалыг тухай бүр цахим хуудсанд байршуулан мэдээлдэг. 24 цагийн мэдээлэл дамжуулах утас, жижүүр шинжээчид ажиллуулж байгаа.	хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулан мэдээлсэн байна. Тайланг 13-р Хавсралтын дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагад англи, орос хэл дээр хөрвүүлэн танилцуулсан байна.	зөвлөмжүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлж байна. Тайлангийн хугацаанд нийт 2 шинжлэн шалгасан тайлан, дүгнэлт, 10 аюулгүй ажиллагааны зөвлөмжийг шинээр оруулан 2 журмыг өөрчлөлт оруулан шинэчлэн байршуулаад байна. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж, мөрдөж байгаа бүх хууль тогтоомж, дүрэм журам, хүний нөөцийн үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичиг, тушаал шийдвэрүүдийг цахим хуудсанд байршуулж, шинэчилж байна. Албаны даргын гаргасан нийтэд хамаатай тушаал, шийдвэрийг он, оноор нь гаргасан ба агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн бүртгэл судалгаанд суурилан осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийн, статистик судалгаа гарган, байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлж байна.	
10	4.3	Албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ	ОУИНБ-ын 13-р хавсралтын дагуу агаарын хөлгийн үйлдвэрлэгч, зохион бүтээгч, эзэмшигч улсууд, санамж бичиг байгуулсан шинжлэн шалгах байгууллагуудт ай агаарын	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: Шинжлэн шалгах ажиллагаанд тухай бүрт хамтарч ажиллана. Шинжээчдийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг авч, туршлага солилцон гадаад хамтын ажиллагааг	Осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд ИКАО болон агаарын хөлгийн үйлдвэрлэгч, зохион бүтээгч, ашиглагч эзэмшигч орнуудын шинжлэн шалгах байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцон тогтмол хамтарч ажилладаг. В767-300 маягийн агаарын хөлөг, Н125 маягийн нисдэг тэрэгний осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд үйлдвэрлэгч улс болох АНУ, Франц улсын шинжлэн шалгах байгууллага, шинжилгээний лаборатортай үл эвдэх сорил, металын шинжилгээ хийх, дүгнэлт гаргах ажиллагаанд хамтран ажиллаж байна.	100

				хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамтран ажилладаг.	сайжруулсан байна.	НТОЗШША-ны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулсан. Онцгой байдлын улмаас төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж, зарим гадаад арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хойшлогдоод байна.	
11	4.4	Иргэний нисэхийн дүрэм ИНД-203 “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах” дүрмийн англи, монгол хэл дээрх хувилбарыг шинэчлэх, өөрчлөлт оруулах санал өгнө.	Санал өгсөн эсэх	Иргэний нисэхийн багц дүрэм шинэчлэх ажиллагаа явагдаж байгаа.	Хагас жилийн байдлаар: Олон улсын иргэний нисэхийн стандарт шаардлагад нийцүүлэх талаар Иргэний нисэхийн дүрэмд судалгаа хийнэ. Жилийн эцсийн байдлаар: Олон улсын иргэний нисэхийн стандарт шаардлагад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрэм-203-д тодорхой саналыг өгсөн байна.	Иргэний нисэхийн шинэчлэн боловсруулагдаж байгаа дүрмийн төсөлд саналаа тогтмол өгч ажилладаг. ЗТХЯ-ны Бодлогын зөвлөлийн гишүүнд шинжээч томилогдон ажиллаж байна. Энэ зөвлөлийн хүрээнд ИНБД-ийн ИНД-203-ын талаар санал гаргаж өгсөн. “Нислэгийн болон холбооны яриа бичлэгийг ашиглах журам”-д дүрмийн дагуу өөрчлөлт оруулах санал гаргаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг 2022.04.27-нд оруулж хүргүүлсэн. Иргэний нисэхийн тухай хуулийн төсөлд санал өгч, ажлын хэсэгт шинжээч оролцуулан ажилласан. 2022.09.30-ны 72/22 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ИНБХЗГ-т хүргүүлсэн.	100

ТАВ.ТӨСӨВ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

12	5.1	Албаны 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулна.	Төсвийг батлуулсан эсэх	ИНЕГ-ын төсөвтэй хамт хэрэгждэг.	Хагас жилийн байдлаар: Албаны 2022 оны зардлын төсвийг батлуулсан байна.	Албаны 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв ИНЕГ-ын төсөвт хамт тусгагдан батлагдсан байна.	100
13	5.2	Албаны төсөв, хөрөнгө, санхүүгийн бүртгэл хөтлөх, хагас болон бүтэн жилийн тайлан гаргана.	Тайлан гаргасан эсэх	Албаны төсөв, хөрөнгийн бүртгэлийг тогтмол хийдэг. ИНЕГ-тай хамтран гаргадаг.	Жилийн эцсийн байдлаар: Зардлын гүйцэтгэл тайланг гаргаж танилцуулах, төсвийн алдагдалгүй, зөрчил дутагдалгүй хэрэгжүүлсэн байна.	Албаны төсөв ИНЕГ-ын төсөвт тусгагдан хамт хэрэгжиж байна. Тусдаа төсөв батлагдаагүй учир төсвийн гүйцэтгэл нэгтгэгдэж гарна. 2022.12.19-ны байдлаар НТОЗШША-ны гүйцэтгэл 309,891.3 төгрөг байна. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж бүртгэсэн. Дутагдал, зөрчил илрээгүй байна.	100
14	5.3	Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай багаж тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл зэргийн нөөцийг бүрдүүлж, байнгын бэлэн байдалд	Нөөцийг бүрдүүлсэн, бэлэн байдалд байлгаж байгаа эсэх,	Албаны дүрмийн 3.4.9, холбогдох журам, нормын дагуу бэлтгэгдэнэ Өмнөх онуудад тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нөөц бүрдүүлсэн.	Хагас жилийн байдлаар: Албаны дүрмийн 3.4.9, холбогдох журам, нормын дагуу хяналт тавин, шаардлагатай иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргана. Жилийн эцсийн байдлаар: Албаны дүрмийн 3.4.9, холбогдох	Холбогдох журам, нормын дагуу хяналт тавин шаардлагатай иж бүрдэл, хэрэгсэл, төхөөрөмжийн судалгааг гаргасан. Онцгой байдлын улмаас энэ оны төсөвт хэмнэлт хийгдэж, ямар ч тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах ажиллагаа нэмж хийгдээгүй байна. Судалгаагаар 2022 онд Хөдөлмөр хамгаалал, нормын хувцас 6 шинжээчид зориулж 3990000, багаж хэрэгсэлд 21100000, бусад 1700400 төгрөг, нийт 26790400 төгрөгний зардал шаардлагатай байсан. Өмнөх онуудад авч хэрэглэж буй тоног төхөөрөмж, хэрэгслүүдийг ажлын бэлэн байдалд байлгаж байна.	70

		байлгана.			журам, дагуу бэлэн байлгана.	нормын бэлтгэж, байдалд		
ЗУРГАА. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ								
15	6.1	Иргэний нисэхийн осол, зөрчлийн мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийнэ.	Судалгаа шинжилгээний үр дүнг тайлагнасан эсэх	13-р Хавсралт, ИНД-203, албаны дүрмийн 3.3.12-ийн дагуу 2010-2021 онд гарсан осол, зөрчлийн мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийгдэж, дүгнэлтийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.	Хагас жилийн байдлаар: Осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийнэ. Жилийн эцсийн байдлаар: Мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, тайлбар гарган тайлагнасан байна.		Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн бүртгэл судалгаанд суурилан осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийн 2016 оноос 2022 оны байдлаар статистик судалгаа гаргасан. Танилцуулга, материалыг сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар 2022.04.15-ны 35/22 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн.	70
16	6.2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, ЗТХ-ийн сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, ил тод, нээлттэй	Хугацаандаа тайлагнасан эсэх	2021 онд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ЗТХЯ-ны ТЗУГ, ХШУДАГ-т тайлагнасан.	Хагас жил, жилийн эцсийн байдлаар: Биелэлтийг бүрэн гарган хугацаанд нь тайлагнана.		Албаны чиг үүрэгт хамааралтай албан даалгаврын 1 дүгээр улирлын биелэлтийг 2022.03.10-нд, 2 дугаар улирлын биелэлтийг гарган, тайланг 2022.06.07-13-нд, 3 дугаар улирлын тайланг 2022.09.05-нд, 4 дүгээр улирлын тайланг 2022.12.06-ны өдөр ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. Үүнд: хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-0, Сайдын тушаалын биелэлт-6, ил тод байдлын шалгуур үзүүлэлт-14, СЗШХ-ны даалгавар-3 биелэлтийг гаргаж тайлагнасан байна. Зам, Тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн	100

		байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг ханган тайлагнана.			худалдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу НТОЗШША-ны эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх танилцуулгыг гарган ЗТХЯ-ны ИНБХЗГ-т 2022.08.31-ний 62/22 тоотор хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	--

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ
ДОЛОО. “ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ ДУНД ХУГАЦАА (2020-2024)-НЫ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

17	7.1	Ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.	Хэрэгжилтийн байдлаар	-	<p>Хагас жилийн байдлаар: Удирдах ажилтанд тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн хэмжээнд нэвтрүүлж, бусад ажилтны тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд</p>	<p>Үйл ажиллагааны онцлогоос хамаарч зөвхөн албаны даргын тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж албаны бичиг хэрэг хөтлөлтөд ашиглаж байна. Токен төхөөрөмж захиалан авч, гэрээ байгуулан баталгаажуулсан. Шаардлагатай тохиолдолд нэмэлт төхөөрөмж QR код авч ашиглахаар шийдвэрлэв.</p>	70
----	-----	---	-----------------------	---	--	---	----

					бүрэн ашигласан байна.		
18	7.2	Албаны чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дэвшилтэд техник технологи, инновацийн талаар туршлага судлах, хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа хийх.	Судалгааны ажлын тоо	-	<p>Хагас жилийн байдлаар: Ажлын цар хүрээгээ тогтоож, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна.</p> <p>Жилийн эцсийн байдлаар: Нийтдээ 2-оос доошгүй судалгааны ажлын эцсийн тайланг яаманд танилцуулсан байна.</p>	<p>Албаны үндсэн чиг үүрэг осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн нислэгийн өгөгдөл болон яриа бичлэгийн төхөөрөмжийн /FDR/CVR/ бичлэгийг тайлж унших ажиллагааг сайжруулах зорилгоор</p> <ol style="list-style-type: none"> 1. Шинэ програм хангамж, 2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийг судлаж, нэвтрүүлэх ажиллагаа хийгдэж байна. <p>Канад улсын Planesceines компаний шинэ технологи болох FAV-INV шинэ системийн талаарх судалгаа хийсэн.</p> <p>АНУ-ын Honeywell, L3-Com-ын тоног төхөөрөмжүүдээс худалдан авахаар судалгаа хийв. Цаашид нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, шинжлэн шалгах ажиллагаанд нэвтрүүлэх зорилт тавиад байна.</p> <p>Санхүүгийн асуудлаас болж шинэ програм хангамж, төхөөрөмж худалдан авах ажиллагаа шийдэгдээгүй, хойшлогдсон байна.</p>	70
19	7.3	Албаны чиг үүргийн хүрээнд цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааны-хаа талаар иргэд, олон	Хэрэгжилтийн байдлаар	-	<p>Жилийн эцсийн байдлаар: Цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна.</p>	<p>Албаны талаарх мэдээлэл, үйл ажиллагааны талаар цахим хуудсаар ил тод мэдээлдэг. Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан тайлан, дүн шинжилгээ, дүгнэлт, аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг он, оноор нь гарган тухай бүр байршуулдаг.</p> <p>Нийт 65 мэдээлэл нэмж байршуулсан байна. Албан ёсны болон сайн дурын мэдээлэл өгөх бүх</p>	90

	нийтэд сурталчлан таниулах.				арга хэмжээг авч ажиллаж байна.	
--	-----------------------------	--	--	--	---------------------------------	--

Төлөвлөгөө хянасан:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Төлөвлөгөө тайлагнасан:

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

Төсвийн ерөнхийлөн захирагч

С.БЯМБАЦОГТ



Төсвийн шууд захирагч

Ж.ЦОЛМОН

